



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 412

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гадаадын иргэн, харьяатын газрын харьяа Буянт-Ухаа дахь газар, Баруун бүс дэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 104,000,000.00 (нэг зуун дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 62,298,872.00 (жаран хоёр сая хоёр зуун ерэн найман мянга найман зуун далан хоёр) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан эд хөрөнгийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Билгүүн, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Д.Мөрөн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА



0002769

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн  
 №... дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ХАРЬАА БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗАР, БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН  
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ӨРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД  
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглал тэд орсон он	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан эзлэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэх хуулийн этгээд	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	"Делика" автомашин, 04-35 УНЧ (арал рд6w0702530)	2011	ш	1	19,000,000.00	19,000,000.00	-	ГИХГ-ын Буянт- Ухаа дахь газар	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
2	"Тоёота ландрейзер-200" автомашин, 20-02 ХОУ (арал jtmv09j9b4053385)	2011	ш	1	85,000,000.00	62,298,872.00	22,701,128.00	ГИХГ-ын Баруун бүс дэх газар	
	<b>Нийт дүн</b>				<b>104,000,000.00</b>	<b>81,298,872.00</b>	<b>22,701,128.00</b>		